



ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН 2022 ОНЫ 04 ДҮГЭЭР САРД ХИЙСЭН АЖЛЫН ТАЙЛАН

2022.04.25

Дархан-Уул аймаг

1. ГАЗРЫН ХАРИЛЦААНЫ ЧИГЛЭЛ


Газар зохион байгуулалтын төлөвлөлт, өмчлөлийн чиглэлээр:

- ✚ Дархан-Уул аймгийн 2022 оны газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөөг сурталчлах ажлыг байгууллагын www.darkhan.gazar.gov.mn цахим хуудас болон фэйсбүүк, www.Egazar.gov.mn цахим хуудсаар иргэн аж ахуйн нэгж байгууллагад ил тод нээлттэй сурталчлах ажлыг зохион байгуулан ажиллаж байна.
- ✚ Тухайн сард www.egazar.gov.mn цахим хуудаснаас 2022 оны тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдсан байршлыг харах зааварыг орон нутгийн телевиз болох TV -12, RJB телевиз, DBS телевизээр иргэн, хуулийн этгээд, олон нийтэд мэдээллийг өгч ажилласан.



Зураг Газар зохион байгуулалтын төлөвлөгөөг иргэдэд сурталчилсан


- ✚ Газрын харилцааны ажилтны өдрийг угтан “Газрын харилцаа, цахим шилжилт” нээлттэй хаалганы өдрийг 2022 оны 04 дүгээр сарын 08,09, 10-ны өдрүүдэд Дархан сумын 1-15 дугаар баг, Малчин, Өргөө багууд дээр мөн Хонгор сум, Орхон, Шарын гол сумуудад тус тус зохион байгуулан ажиллаа. .





Зураг 2. Нээлттэй хаалга, нөхөн бүрдүүлэлт, цахим газрын харилцаа

- ✚ Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд эрчимжсэн аж ахуйг хөгжүүлэх бүсийн тохиромжтой байдлын үнэлгээг 11 байршилд хийсэн. Орхон, Хонгор сумын нутаг дэвсгэрт төлөвлөгөөг боловсруулан Дархан сумын Засаг даргын тамгын газартай хамтран ажилласан. Нийт 72 нэгж талбарыг төлөвлөж 2022 оны 04 дүгээр сарын 28-ны өдөр улаан шугамыг татаж ажиллаа.






Монгол Улсын иргэнд газар өмчлүүлийн чиглэлээр:

- Дархан-Уул аймгийн хэмжээнд Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль хэрэгжиж эхэлсэнээс хойших хугацаанд өмчлүүлсэн газрын судалгааг гаргаж ажилласан. Аймгийн хэмжээнд 2022 онд 444 иргэнд 34,98 га буюу хуучин эзэмшиж байгаа газрыг газрыг өмчлүүлэхээр төлөвлөсөн. Дархан сумд 1, 2, 3, 5, 6, 7, 8, 15, Малчин багийн нутаг дэвсгэрт 194 иргэнд 13,87 га газрыг 2022 онд өмчлүүлэхээр батлагдсан.

2022 онд иргэнд гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар өмчлүүлэх газрын хэмжээ, байршил, зориулалт																					
№	Сумын нэр	Өмчлүүлэх газрын байршил	Иргэдэд өмчлүүлэх газрын нийт хэмжээ /га-аар /	Өмчлүүлэх газрын зориулалт /га-аар/							Өмчлүүлэх иргэдийн тоо										
				Иргэдэд үнэгүй өмчлүүлэх газрын нийт хэмжээ	Үүнээс			Аж ахуйн зориулалтаар өмчлүүлэх газрын нийт хэмжээ /га/	Үүнээс		Газар өмчлүүлэх нийт иргэдийн тоо	Гэр бүлийн хэрэгцээнд үнэгүй өмчлүүлэх иргэдийн тоо	Үүнээс			Аж ахуйн зориулалтаар өмчлүүлэх иргэдийн тоо	Үүнээс				
Одоо эзэмшиж байгаа газрыг өмчлүүлэх нийт хэмжээ	Шинээр өмчлүүлэх газрын нийт хэмжээ	Улсын чанартай автозамын дагуу өмчлүүлэх газрын нийт хэмжээ	Ур тарианы		Төмс, хүнсний ногооны	Газар тариалангийнхаас бусад	Одоо эзэмшиж байгаа газраа өмчлүүлэх		Шинээр газар өмчлөх	Улсын чанартай авто замны дагуу өмчлөх			Ур тарианы	Төмс, хүнсний ногооны	Газар тариалангийнхаас бусад						
0	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	16	17	18	19	20	
1	Дархан сум	1-р баг	1.54	1.54	1.54							22	22	22							
		2-р баг	1.61	1.61	1.61								23	23	23						
		3-р баг	2.24	2.24	2.24								32	32	32						
		5-р баг	0.91	0.91	0.91								13	13	13						
		6-р баг	1.75	1.75	1.75								35	35	35						
		7-р баг	1.36	1.36	1.36								18	18	18						
		8-р баг	2.11	2.11	2.11								17	17	17						
		15-р баг	1.02	1.02	1.02								16	16	16						
	Малчин	1.33	1.33	1.33							19	19	19								
	Нийт дүн		13.87	13.87	13.87							195	195	195							



№	Аймаг, нийслэлийн нутаг	Өмчлүүлэх газрын байршил	Иргэнд өмчлүүлэх газрын нийт хэмжээ (га)	Гэр бүлийн хэрэгцээнд үнэгүй өмчлүүлэх газрын нийт хэмжээ	Түүнээс			Аж ахуйн зориулалтаар өмчлүүлэх газрын нийт хэмжээ	Ур тарианы	Төмс, хүнсний ногооны	Газар тариалангийнхаас бусад
					Одоо эзэмшиж байгаа газрыг өмчлүүлэх	Шинээр өмчлүүлэх	Улсын чанартай автозамын дагуу өмчлүүлэх				
1	Дархан-Уул	Сумын нэг	41.88	41.32	7.26	34.33	0.13	0.13			
2	Баянхонгор	Сумын нэг	106.54	106.44	138.41	30.47	7.56	0.35			
3	Булган	Сумын нэг	32.09	32.19	0.2	31.99					
4	Булган	Сумын нэг	108.47	108.47							
5	Говь-Алтай	Сумын нэг	18.84	18.84	0.12	18.82					
6	Говь-Сүмбэр	Сумын нэг	16.126	16.126	0.365	0.223	15.54				
7	Дархан-Уул	Сумын нэг	34.98	34.98	0.000	34.98					
8	Дорноговь	Сумын нэг	31.9515	31.9515	1.4431	30.5024					
9	Дорнод	Сумын нэг	141.895	141.895	0.14	141.745					
10	Дундговь	Сумын нэг	114.59	114.59	2.65	113.94					
11	Завхан	Сумын нэг	29.89	29.89	7.8	18.04					
12	Завхан	Сумын нэг	45.2	45.2	12.9	32.3					
13	Завхан	Сумын нэг	117.58	117.58	4.13	111.07	2.19				
14	Өвөрхангай	Сумын нэг	73.27	73.27	0.79	72.48					
15	Сүхбаатар	Сумын нэг	188.2	188.2	0.12	188.01					
16	Сүхбаатар	Сумын нэг	616.83	616.83	105.27	437.59	75.36	0.17			
17	Төв	Сумын нэг	1525.31	1525.14	65.06	1425.05	38.13	30			
18	Увс	Сумын нэг	65.01	65.01	23.87	11.14					
19	Ховд	Сумын нэг	194.64	194.64	69.43	115					
20	Ховд	Сумын нэг	84.4	84.4	88.5	10.95					

Зураг. Засгийн газрын 121 дүгээр тогтоол 2022 онд иргэнд өмчлүүлэх газар

Өмчлөх эрхээ бусад аймаг, орон нутагт хэрэгжүүлэхээр лавлагааг авсан

иргэдийн судалгаа:

- Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуульд өөрчлөлт орсноос хойш аймгийн хэмжээнд газар өмчлөх эрхээ бусад аймаг, орон нутагт хэрэгжүүлэхээр хүсэлт гаргасан **89** иргэнд лавлагаагаар үйлчилсэн байна
- Аймгийн Цагдаагийн газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар болон Прокурорын газарт шалгагдаж байгаа иргэн, хуулийн этгээдийн 13 албан бичгийн лавлагааг газрын кадастрын мэдээллийн сангаас шүүж хариуг хүргүүлсэн.

Геоземи, зураг зүйн, кадастрын чиглэлээр:



- Геозеги, зураг зүй, кадастрын зураглалын ажил үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй “Елт сүрвэй” “Гео од” ХХК-ний хийж гүйцэтгэсэн орон сууцны 5-н барилгын улаан шугам, 10 авто зам, 2 цахилгааны болон кабелийн шугамын трасын ажлыг шалгаж хүлээн авсан.
- Хаягийн зургийн дагуу 28 иргэн, 11 аж ахуйн нэгжийн эзэмшлийн газар, үл хөдлөх эд хөрөнгөд хаяг дугаар олгосон.
- Шинээр үл хөдлөх эд хөрөнгийн гэрчилгээ авахаар /хувийн сууц, гараж, барилга байгууламж/ хэмжилт хийлгэсэн 30 иргэн, 8 аж ахуйн нэгжийн материалыг хүлээн авч мэдээлийн санд оруулж кадастрын зураг гаргасан.
- Өмчлөх эрхээ бусдад шилжүүлэх хүсэлтээ цахимаар ирүүлсэн 6 иргэний материалыг хянаж өмчлөх эрхийг шилжүүлсэн.
- “Багийн нэрийг УИХ-аар батлуулахад БХБЯ-ыг шаардлагатай мэдээ, мэдээллээр ханган ажиллах” ажлын хүрээнд ГЗБГЗЗГ-аас судалгаа хийж УИХ-д танилцуулсан ажлын тайланд Дархан-Уул аймгийн Дархан сумын Өргөө /17/, Малчин /18/ багуудаас бусад 1-16-н баг нь оноосон нэр байхгүй зөвхөн багийн дугаар баталсан нь Үндсэн хууль, Монгол хэлний тухай, Геодези, зураг зүйн тухай, Газрын тухай хуулиудыг зорчиж байна гэж дурьдагдсан.
- Иймд багуудад оноосон нэр олгох ажлыг хийж гүйцэтгэхдээ тухайн багийн иргэдийн саналыг тусган багийн ИНХ-аар хэлэлцүүлэн нэрийн саналаа ирүүлэх тухай албан бичгийг багуудын Засаг дарга нарт хүргүүлж 16 багийн оноосон нэрийн саналыг хүлээн авч нэгтгэн Дархан сумын Засаг дарга, сумын газар зүйн нэрийн салбар зөвлөлд албан бичгээр хүргүүлсэн.
- Дархан-Уул аймгийн нутаг дэвсгэрт хийгдэх газар зүйн нэрийн тодруулалтын ажлын төсвийг гарган хүргүүлсэн.

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН НИЙТ НУТАГ ДЭВСГЭРТ ГАЗАР ЗҮЙН НЭРИЙН ТОДРУУЛАЛТ ХИЙХ АЖЛЫН ТӨСӨВ
Дархан-Уул аймаг

Үнэлгээний дугаар	Ажлын нэр төрөл	Хэмжих нэгж	Ажлын хэмжээ	Нэгжийн үнэ	Бүгд үнэ сая.төг	Тайлбар үндэслэл
176	Газар зүйн нэрийн тодруулалт / ажлын зэрэг I /	нэр	50	35182	1.759.100	"Геодези, зураг зүйн жишиг үнэ БД81-103-21"-ийн 9.6. Газар зүйн нэрийн тодруулалт №176,177,178
177	Газар зүйн нэрийн тодруулалт / ажлын зэрэг II /	нэр	791	43938	34.754.958	
178	Газар зүйн нэрийн тодруулалт / ажлын зэрэг III /	нэр	1000	56448	56.448.000	
Нийт					92.962.058	

Талбар: Нэгж үнийг БХБ сайдын 2021 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн 123-р тушаалаар батлагдсан "геодези, зураг зүйн ажлын жишиг үнэ БД81-103-21" -ийн баримтлан тооцоо.

Ажлын бүрдэл: Техникийн төсөл, ажлын даалгавар авч судлах. Газар зүйн нэрийн материалтай танилцаж суурин судалгаа хийх. Орон нутгийн төрийн захиргааны байгууллагаар захирамж шийдвэр гаргуулах. Газар зүйн нэрийн тодруулалт хийх тухайн нутагт үе залгамжлан оршин сууж амьдарч байгаа нутгийн уугуул иргэдийн туслалцааг авч газар нутгийн байдлыг сайн мэдэх хүмүүсээр газарчлуулан гүйцэтгэнэ. Газар зүйн нэрийн өмнө судалсан нэрийг газар орчны байдалтай сайтар тулгаж шалгах, газрын зурагт байхгүй нэрийг зурагт оруулж баталгаажуулах. Цуглуулсан газар зүйн нэрийг солилцохжуулах, мэдээллийн сан үүсгэх, орон нутгийн төр захиргааны байгууллагаар баталгаажуулах. Газар зүйн нэрийг аймаг сумаар ангилан жагсаалт хийх. Газар зүйн нэрийн хувийн хэрэг хөтлөх. Газар зүйн нэрийн жагсаалт гарган CD-д бичиж хэвлэх. Ахлаа шалгуулж захиалагч байгууллагад хүлээлгэн өгөх.

- Орон нутгийн төсвийн хөрөнгөөр “Хаягжуулалт” төслийн хүрээнд Дархан сумын 4,5,6,7, Өргөө багуудын нутаг дэвсгэрт хийгдэх гудамж өргөн чөлөө болон барилга байгууламжийн хаягийн тэмдэг үйлдвэрлэх, байршуулах ажлын даалгаварыг хүргүүлсэн.
- “Дархан даллах” ХХК-ний гомдол, санал хүсэлтийн дагуу Дархан сумын 5 дугаар баг 20-р хороололд байрлах тус компианы эзэмшлийн газарт хэмжилт хийж кадастрын зургийг гарган хүргүүлсэн.
- Зураглалыг гаргахдаа тухайн орчинд шинээр хийгдсэн явган хүний зам болон авто машины зорчих хэсгийн газрыг хасаж тухайн компианы эзэмшлийн



газрыг боломжтой тал руу шилжүүлэх замаар талбайн хэмжээг өөрчлөхгүйгээр /1186 м2 / хийж гүйцэтгэлээ.

- ✚ Хонгор сумын 1 дүгээр багийн нутагт олгох малтай иргэдийн сууршуулах бүсэд 177 солбицол хатгаж 73 нэгж талбар байршуулах ажлыг хийж гүйцэтгэсэн.

Газрын төлбөрийн талаар:

✚ Дархан сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2021 оны 28 дугаар тогтоолын дагуу Дархан сумын 5-н байршилд Газрын дуудлага худалдааг 2022 оны 04-р сарын 08-ны өдөр зохион байгуулахаар аймгийн Засаг даргын 2022.03.04-ны өдрийн 01-А/49 дүгээр захирамж гаргуулж, газрын биржийн цахим систем /www.mle.mn/-д байршуулсан. Аймгийн Засаг даргын 2022.04.05-ний өдрийн 01-А/89 дүгээр захирамжаар газар эзэмшүүлэх дуудлага худалдааг зохион байгуулах ажлын хэсэг байгуулагдаж, 2022.04.08-ний өдөр зохион байгуулсан. Дуудлага худалдаанд Сайнбуян овогтой Туяабаяр /РД: ТЯ80110421/ оролцох хүсэлт ирүүлсэн бөгөөд дуудлага худалдаа явуулах журмын 9.11 дэх хэсэгт заасны дагуу 1 оролцогч ирсэн тул дуудлага худалдаа явагдаагүй болно.

✚ Газрын төлбөрийн тухай хуулийн 6.3-д 2021.07.07-ны өдрийн хуулиар нэмэлт өөрчлөлт орж "сум, дүүргийн" гэснийг "аймаг, нийслэлийн" гэж өөрчлөлт оруулсан бөгөөд 2022.01.01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөж байгаатай холбогдуулан Дархан-Уул аймгийн хэмжээнд "Газрын төлбөрийн итгэлцүүрийг хэрэглэх газрын зааг, хязгаар, итгэлцүүрийн тоон утга"-ыг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 8 дахь удаагийн сонгуулийн ээлжит 9 дүгээр хуралдаанаар 2022.03.21-ний өдөр хэлэлцэн батлуулсан. Хууль зүй, дотоод хэргийн яамнаас дүгнэлт ирүүлсний дагуу засварлан эцсийн байдлаар мэдээллийн санд бүртгүүлэхээр ажиллаж байна.

✚ 2022 онд аймгийн хэмжээнд 36 нэгж талбарт газрын дуудлага худалдаа зохион байгуулах, Дархан сумын хэмжээнд байгаа 1300 гаруй гаражийн судалгааг гаргаж багийн Засаг дарга нарт хүргүүлсэн бөгөөд ГАРАЖуудын хаалгыг нэг ижил СААРАЛ өнгөөр будуулах, хаалганы гадна хүрээг цагаанаар будуулах, эмульсдэх нэгдсэн хаягжуулалтын ажлыг эхлүүлээд байна.

1. Аймгийн хэмжээний 26 багийн Засаг даргатай уулзаж, газрын цахим систем egazar.gov.mn-ийг сурталчлан таниулж, "Газрын харилцааны хөгжил-Багаас эхтэй" уриалга дэвшүүлж, багийн төвүүд дээр ажиллаж цагийн хуваарийг батлан гаргаж хуваарийн дагуу ажилласан.



Шарын гол сум:



- ✚ Худалдах худалдан авах гэрээний үндсэн дээр газар өмчилж авах 8, өргөдөл 5, барьцаа 1 тус тус бүртгэсэн. Сумын Засаг даргын захирамжаар эзэмшиж буй газраа өмчлөх 1, газар эзэмших эрх дуусгавар болсон 4, газар эзэмшүүлэх эрх шилжүүлэх 1 иргэний материалыг цахим оруулсан. Гаражын зориулалтаар 18, амины орон сууцны зориулалтаар 1, төмс хүнсний ногооны зориулалтаар 1, жимс жимсгэнэ тарих 1, нийт 26 иргэний материалыг нөхөн бүрдүүлэлтэд оруулсан. Нээлттэй хаалганы өдөрлөгийг сумын ЗДТГ, ГХБХГ-тай хамтран зохион байгуулж нийт 75 иргэн, хуулийн этгээдэд газрын үйлчилгээг үзүүлсэн. Үерийн болон ундны усны давхцалтай зургийг ГХБХБГ-т ирүүлсэн. Төмс хүнсний ногоо, жимс, жимсгэнэ тариалах зориулалтаар шинээр олгох боломжтой газрын судалгааг Дархан-Уул аймгийн Хүнс хөдөө аж ахуйн газарт хүргүүлсэн.

2. БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЧИГЛЭЛ

Барилгын хяналтын чиглэл:

Барилга байгууламжийн ашиглалтад оруулах комиссыг зохион байгуулсан талаар:

- ✚ Засгийн газрын 2011 оны 212-р тогтоолоор батлагдсан Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм, Дархан-Уул аймгийн засаг даргын 2021 оны 01-А/313 тоот томилогдсон захирамжийн дагуу барилгын техникийн бичиг баримтыг хянаж үзэн 7 барилгад ашиглалтад оруулах үйл ажиллагааг зохион байгуулж ажилласан. Үүнд:
 - “Газар буудай” ХХК-ний 15*21, 12*18 хэмжээтэй оффис, үйлчилгээний барилга



- Хонгор сумын нутаг дэвсгэрт баригдсан 111 ширхэг гадна гэрэлтүүлэг барилга
- Дархан сум, 13-р баг, Эрд хул ХХК -ийн газрын тосы агуулахын гадна цахилгаан хангамж



- 2200 хүний суудалтай спорт цогцолборын гадна цахилгааны шугамын барилга



- Иргэн Ц.Даландэлгэрийн үйлчилгээний зориулалттай зoorьтой, 5 давхар үйлчилгээний барилга
- “Газ ойл нефть” ХХК-ний Олон төрөлт түлш түгээх станц барилга



Барилга байгууламжийг эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл олгосон талаар:
Засгийн газрын 2021 оны 213 дүгээр тогтоолын дагуу барилгын ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрлийг 5 барилга байгууламжид олгосон. Үүнд:

- “Очир дархан” ХХК-ний үйлчилгээтэй 54 айлын нийтийн орон сууцны барилга
- иргэн С.Ганзориг, Д.Батбаяр нарын амины орон сууцны дулааны шугам
- Дархан-Уул аймгийн Цагдаагийн газрын өргөтгөлийн барилга
- Иргэн Д.Бат-Оршихын 90 айлын орон сууцны барилга
- Дархан сумын 5.6.7-р баг дулаан дамжуулах сүлжээний ТК27-ТК39 худгийн хооронд дулааны шугамын шинэчлэлтийн ажил




- ✚ 2022.04.16-нд Дархан-Уул аймгийн “Барилгын салбарын удирдах ажилтны зөвлөгөөн-2022”, “Дархан барилга экспо-2022” хувийн хэвшилтэй хамтран зохион байгууллаа. Зөвлөгөөнд Барилга, хот байгуулалтын яам, Барилгын хөгжлийн төв, аймаг орон нутгийн удирдлагуудыг хамруулсан 60 гаруй төлөөлөл оролцож, салбарын бодлого, хөгжлийн чиг хандлага, хөрөнгө оруулалт, хэрэгжиж буй төсөл хөтөлбөр зэрэг өргөн сэдвийн хүрээнд зөвлөлдөв. “Дархан барилга экспо-2022”-д барилга угсралт, бүтээн байгуулалт, материал үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг 26 иргэн, хуулийн этгээд оролцож, иргэдэд орон сууцны үнэ ханш, барилгын материалын мэдээллийг хүргэв.

Инженер, дэд бүтцийн хүрээнд:

- ✚ Засгийн газрын 212-р тогтоолын дагуу 2 барилгад ашиглалтад оруулах комиссын актыг баталгаажуулж өгсөн. Үүнд:
 - Дархан сумын 13-р баг үйлдвэрийн районд байрлах Эрд хул ХХК-ны 6кВ кабель шугам 160кВ дэд станц
 - Хонгор сумын төвийн цахилгаан эрчим хүчний 35кВ агаарын шугам, дэд станцын засвар шинэчлэлтийн ажил
 - Дархан сум 5-р баг Хүслэн төвийн өргөтгөлийн барилгуудад комисс ажилласан.
- ✚ Дархан-Уул аймгийн Засаг даргын 2022.02.28 өдрийн 01-А/45 захирамжаар Шар усны үерээс урьдчилан сэргийлэх нэгдсэн арга хэмжээг зохион байгуулах тухай захирамжийн дагуу ажлын хэсэгтэй хамтран үзлэг шалгалт хийж, зураг төслийг боловсруулан ажлын хэсгийн ахлагчид танилцуулсан.

Хот байгуулалтын кадастр, зураг төслийн хүрээнд:

- ✚ Архитектур төлөвлөлтийн даалгаврын 11 хүсэлт ирсэнийг судлаж үзээд 6 архитектур төлөвлөлтийн даалгавар батлуулж хүлээлгэж өгөв.




Нэгж талбарын нөхөн бүрдүүлэлтийн буюу нэмэлт ажлын чиглэлээр:

- ✓ 594 иргэний мэдээллийг нэгж талбартай холбогдсон үгүйг нэг бүрчлэн шалгаж агентлаг руу явуулах жагсаалт бэлдсэн.
- ✓ 216 хүний өргөдлийг нэгж талбартай нь холбож шинэчилсэн бүртгэлд бүрэн хамруулсан.
- ✓ Өдөр бүр шинэчилсэн бүртгэлд хамрагдахаар ирсэн иргэний мэдээллийг шалгаж, цахим бүртгэлд хамрагдах шаардлагатай 55 иргэний өргөдлийг хүлээн авч мэдээлэл зөвлөгөө өгч ажилласан.
- ✓ Мал бүхий иргэдийг хотоос гадагш гаргах аймгийн Засаг даргын шийдвэрийн дагуу мэргэжилтнүүдийн хамт нэгж талбарт улаан шугам тавьсан.

Барилгын материал чиглэлээр:

- ✚ Улаанбаатар барилга-2022 цуврал үзэсгэлэнд оролцож хөтөлбөрийн дагуу Барилгын материалын шинэ техник технологи, өдөрлөг, Барилгын салбарын шинэчлэлийн мэдээлэл авсан. Зохион байгуулж буй сургалтанд хамрагдаж, цаашид хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг танилцуулсан.



- ✚ 2022,04,26-нд лабораторийн 2 тоног төхөөрөмжийг 380-д холбож ажиллагаанд оруулсан. Улаанбаатар хотоос хэмжилзүйн Эталон ХХК ирж тохируулга хийхээс өмнө бэлтгэл ажлыг хангаж ажиллаа.



- ✚ Мал бүхий иргэдийг төвөөс гадагш нэг цэгт төвлөрүүлж Төмсний бригадад 6 га газар олгосон. Энэ ажилтай холбоотой 2022,04,27-28-ны өдрүүдэд ДарханЭрдэс Шохойт Шийр ХХК, Силикат ХК –удаас тус тус 5 тн нунтаг шохой авч 60 айлын хашааны газрыг нунтаг шохойгоор шугам татан тэмдэгжүүлсэн. Нийгмийн хариуцлагын үүднээс дээрх 2 компани үнэ төлбөргүй нунтаг шохойг машинаар хүргэж бидний ажилд тусалсан.



3. ЗАХИРГАА, ХҮНИЙ НӨӨЦ, ДОТООД АЖЛЫН ЧИГЛЭЛ:

Шүүхийн мэдээлэл:

- ✚ О.Соёлмаа нарын нэхэмжлэлтэй, гуравдагч этгээдийн сөрөг нэхэмжлэлтэй хариуцагчаар ГХБХБГ-оролцсон 2022/01/13 дугаар 62 Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн Магадлалаар 2021/11/01-ний өдрийн Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн Дугаар 16 шийдвэрийг хэвээр үлдээж, давж заалдах гомдлыг хангаагүй болно. Энэхүү давж заалдах шатны шүүхийн шийдвэрт нэхэмжлэгч талаас гомдол ирүүлсний дагуу хяналтын шатны шүүх рүү шилжсэн.
- ✚ Дархан Ти Ви ХХК-ний нэхэмжлэлтэй хариуцагчаар Аймгийн ЗД-ын итгэмжлэгдсэн төлөөлөгч Б.Золбаясах оролцсон 2022/02/10-ны өдрийн Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 114/ ШШ2022/0002 шийдвэрийг эс зөвшөөрч, Нэхэмжлэгч талаас Захиргааны хэргийн Давж заалдах шатны шүүхэд гомдол гаргасны шүүх хуралдаан 2022/04/21-ний өдрийн шийдвэрээр Анхан шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээж, нэхэмжлэгчийн гомдлыг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн.
- ✚ Улаанбаатар менежмент ХХК-ний нэхэмжлэлтэй аймгийн Засаг даргад холбогдох Захиргааны хэрэгт холбогдуулж газар эзэмших эрхийг шилжүүлэхгүй байгаа нь хууль бус гэсэн нэхэмжлэлийн шаардлагад ГХБХБГ-ы ЗХАХМэргэжилтэн Б.Золбаясах хариу тайлбарыг боловсруулж Захиргааны



хэргийн анхан шатны шүүхэд тайлбарыг хүргүүлсэн. Одоогоор шүүх хуралдааны тов зарлагдаагүй байна.

- ✚ “Бадрал Өргөө” Дархан-Уул аймгийн Захиргааны хэргийн анхан шатны шүүхэд нэхэмжлэл гаргасантай холбогдуулан шүүхээс тухайн газарт Ачиж буулгах зориулалтын дагуу ямар нэг объект, суурь, бүтээн байгуулалт хийгдсэн талаар газар дээрх үзлэгийг хийх, фото зургаар баримтжуулах зэргээр ажиллаа, тус байгууллагаас Геодези, зураг зүйн асуудал хариуцсан мэргэжилтэн Б.Мөнхчулуун, Захиргаа хуулийн асуудал хариуцсан мэргэжилтэн Б.Золбаясах нар оролцсон.

Хүний нөөц:


- ✚ Аймгийн засаг даргын 2022 оны 04 дүгээр сарын 12-ны өдрийн 01-Б/08 захирамжаар ГХБХБГ-ын 4 албан хаагчид ГЗБТӨХАМэргэжилтэн Б.Баярмаад Дэс түшмэлийн Гутгаар зэрэг 20%, ГТТҮХМэргэжилтэн Ц.Чулуунцэцэгт Дэс түшмэлийн Дэд зэрэг 22%, ИДБАХМэргэжилтэн Б.Төмөрт Дэс түшмэлийн Дөтгөөр зэрэг 18%, Шарын гол сумын Газрын даамал Д.Болорцэцэгт Дэс түшмэлийн Дөтгөөр зэрэг 18% нэмэгдлийг олгуулхаар шийдвэр гарсан.

Сургалт, зөвлөгөөн:

- ✚ 2022 оны 04 дугаар сарын 07, 08 -ны өдрүүдэд 21 аймгийн газар зохион байгуулалт, төлөвлөлт газар өмчлөлийн асуудал хариуцсан ахлахуудад Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газраас зохион байгуулсан мэргэж Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газраас зохион байгуулсан.



- ✚ 2022 оны 03 дугаар сарын 22-ны өдөр аймгийн ЗДТГ-ын Хяналт-шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын хэлтсээс зохион байгуулсан “Байгууллагын үр дүнгийн гэрээний хэрхэн үнэлэх” талаар мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх сургалтад хамрагдсан.



- ✚ 2022 оны 03 дугаар сарын 31-ны өдөр байгууллагын хууль эрх зүйн асуудал хариуцсан мэргэжилтэн Б.Золбаясах шинээр батлагдсан Хөдөлмөрийн тухай хуулийн талаар байгууллагын нийт албан хаагчдад сургалтыг хийсэн.



- ✚ Орхон аймгийн Засаг даргын санаачилгаар “Дахин төлөвлөн барилгажуулах дэд бүтэцжүүлэх төслүүд” улсын анхдугаар зөвлөгөөнд 1 өдөр оролцсон.



- ✚ Орхон аймгийн Засаг даргын санаачилгаар “Дахин төлөвлөн барилгажуулах дэд бүтэцжүүлэх төслүүд” улсын анхдугаар зөвлөгөөнд 1 өдөр оролцсон.



- ✚ Орон нутагт эрчим хүчний үр ашгийг дээшлүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах сэдэвт 2 өдрийн сургалтад хамрагдсан.
- ✚ Газрын удирдлагын хэлтсийн дарга Г.Нямдорж, Захиргаа, хуулийн асуудал хариуцсан мэргэжилтэн Б.Золбаясах нар ГЗБГЗЗГ, Удирдлагын академитай хамтран зохион байгуулсан 2 өдрийн танхимаар “мэргэшүүлэх багц цаг”-ийн сургалтад хамрагдаж гэрчилгээ авсан.
- ✚ “Авлигын эсрэг” арга хэмжээний хүрээнд аймгийн дэд хөтөлбөрийг батлагдсаны дагуу төрийн байгууллагуудын удирдах, хүний нөөц, ЭБАТ, ХАСУМ гаргадаг бүх албан хаагчдад Залуучууд театрын их танхимд хагас өдрийн сургалт, мэдээллийг авч хамрагдсан.
- ✚ Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газартай хамтран Улсын үзлэг, тооллогын журам болон цахим сургалтыг 04 дүгээр сарын 26-ны өдөр Залуучууд театрын бага танхимд байгууллагуудын нягтлан бодогч, газрын дарга нар хамрагдсан.
- ✚ Аймгийн архивын тасгаас зохион байгуулсан “Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль”, “Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам”, “”

ЭБАТ:

- ✚ Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Газрын эрх зүйн харилцааны хуралдааны 4 дүгээр сарын хуваарь болон барилгын ажлын хяналтын дагуу Ашиг сонирхлыг зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдлийг 8 албан хаагчаас авч <https://meduuleg.iaac.mn/AOS/Login> бүртгэлд оруулсан. Газрын эрх зүйн харилцааны хуралдааны хуваарийн дагуу хуралдаж нийт 142 иргэн, хуулийн этгээдийн газартай холбоотой материалыг хэлэлцэж шийдвэрлэсэн.

Олон нийтийн ажил:

- ✚ Дархан-Уул аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, ГХУСАЗСЗ-өөс гаргасан “Архидалтын эсрэг” уриалгыг дэмжиж, тодорхой ажил, үйл ажиллагаа зохион байгуулан ажиллаж байна.





- ✚ “Нээлттэй хаалганы өдөрлөг” арга хэмжээг аймгийн хэмжээнд зохион байгуулж газрын харилцаатай холбоотой үйлчилгээг цахим системээр хэрхэн авах талаар сурталчилж, шинэчилсэн бүртгэлд хамрагдсан эсэхийг шалгах, хүсэлтүүдийг илгээхэд туслан, гарын авлага тарааж ажилласан. Мөн газар өмчлөх, эзэмших эрх шилжүүлэх, шинэчилсэн бүртгэлд хамрагдах иргэдийн хүсэлтийг хүлээн авах, газрын кадастрын зургаар үйлчлэх, газрын маргааныг шийдвэрлэх, газрын төлбөр, татварын мэдээлэл өгөх зэрэг нийт 1056 үйлчилгээ үзүүлж ажилласан байна.



- ✚ 2022-04-02-ны өдөр Бүх нийтийн цэвэрлэгээнд байгууллагаараа оролцов. /Сар бүрийн эхний 7 хоногийн Бямба гаригт/
- ✚ Төрийн байгууллагуудын дунд зохион байгуулагдсан дартсын тэмцээнд 2 дугаар байр эзлэж мөнгөн медаль авсан.



Байгууллагын Эцэг эхийн зөвлөл: “Хүүхэд хамгааллын жил 2022 он”

- ✚ Тус байгууллагын 2022 оны эцэг, эхийн зөвлөлийн ажлын төлөвлөгөөнд: Байгууллагын албан хаагчдын хүүхдүүдэд эрүүл мэндийн талаар сургалт зохион байгуулах тусгасаны дагуу нийт 41 хүүхдийг шүдний эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулахаар “Харцтай” шүдний эмнэлэгт 2022-04-25 ны өдрийн 247 тоот албан бичгийг хүргүүлж хамтран ажллахаар болж, судалгааг хүснэгтэн байдлаар хүрүүлж ажилласан.
- ✚ Мөн хүүхдийг орчны эрсдэлээс урьдчилан сэргийлэх “ Нэг дүүгэрт шалга” арга хэмжээнд Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар нэгдсэн.



2022.04.26 № 241
танай -ны № -т

ХАРЗТАЙ ШҮДНИЙ ЭМНЭЛЭГТ

Тус байгууллагын эцэг, эхийн зөвлөлийн 2022 оны ажлын төлөвлөгөөндөө албан хаагчдын хүүхдүүдийн шүдний эрүүл мэндийн талаар зөвлөгөө болон сургалт өгөхөөр тусган ажиллаж байна.

Мөн Дархан-Уул аймаг нь 2022 оныг "Хүүхэд хамгаалал"-ын жил болгон зарласантай холбогдуулан зөвлөгөө болон сургалт, үзлэг оношилгоог хүүхдүүдэд хийж өгч хамтран ажиллаж дэмжлэг үзүүлнэ үү.

ДАРГА Д.БАТЧУЛУУН

45200000339

D:\Sendee\2022\албан тоот\toot AS.240.doc

Дархан-Уул аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар

14m · 🌐

👏 #Хүүхэд #нэгдүгээрт 🎉

Дархан-Уул аймгийн #Газрын #харилцаа, #барилга, #хот #байгуулалтын #газрын албан хаагчдын 39 хүүхдийг шүдний эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулахад дэмжин ажиллахаар болсон #Харзтай #шүдний #эмнэлгийн хамт олонд талархлаа илэрхийлье.




Мэдээлэл технологийн чиглэлээр:


- Дархан-Уул аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын 70376471 нээлттэй утсаар 59, Facebook хуудсанд ирсэн 69 иргэн, ААНБ-ын асуултанд хариулт, зөвлөгөө өгөв. Байгууллагын цахим хуудасны санал гомдол хэсэгт ирсэн асуултуудыг групп-д байрлуулав.




- Байгууллагын цахим хуудсанд АЗДТГ-ын ХШҮХ-ийн сургалтанд хамрагдсан талаарх мэдээлэл, Нээлттэй хаалганы өдөрлөгийн зар, гаражийн хаягжуулалтын мэдээлэл, нээлттэй хаалганы өдөрлөгийн тайлан, Цахим системээр илгээх боломжтой хүсэлтүүдийн цэсийг үүсгэж байрлуулав.
- Байгууллагын цахим хуудасны санал гомдол хэсэгт санал ирсэн огноог бүртгэхээр програмчлав. Байгууллагын болон сумдын даамлуудын фэйсбүүк хуудсан дээр АЗДТГ-ын ХШҮХ-ийн сургалтанд хамрагдсан талаарх мэдээлэл, "Эрсдэлгүй Дархан" аянд ГХБХБГ-ын хамт олон нэгдсэн тухай мэдээлэл, Нээлттэй хаалганы өдөрлөгийн зар, гаражийн хаягжуулалтын мэдээлэл, нээлттэй хаалганы өдөрлөгийн мэдээг 3 удаа, Газрын кадастрын системийн нөхөн бүрдүүлэлтийн ажил дуусахад 12 хоног үлдсэн тухай мэдээ байрлуулав. Байгууллагын Google group үүсгэн, бүх албан хаагчийг бүртгэн, 3 албан хаагчид manager-н эрх олгож, хэрхэн ашиглахыг зааж өгөв.



- ✚ Хонгор сумын газрын даамлын компьютерт тохирох үйлдлийн системийн boot бэлтгэж, форматлан үйлдлийн систем, хэрэглээний програмыг суулгаж, төхөөрөмжүүдийг таниулан, VPN-ийн тохиргоог хийв.



- ✚ Мэргэжилтнүүдийн хаягийн эхийг 3 хувилбараар бэлтгэв.
- ✚ Нээлттэй хаалганы өдөрлөг болох багуудын төвүүд дээр очиж интернэтийн холболт, цахилгааны эх үүсвэрийг үзэж шалгав. /7 газар/ Мэдээллийг хэвлэж мэргэжилтнүүдэд өгөв. Нээлттэй хаалганы өдөрт хэрэглэх брошур, постеруудын эхийг бэлтгэж, брошурыг 700 хувь хэвлэж, хувааж багуудад хуваарилж өгөв. Нээлттэй хаалганы өдөрлөгт явах багуудын компьютерууд дээр VPN-ийн тохиргоог хийж, кодыг өгөв.



Нярав:

- ✚ 80 ширхэг Нэгж талбарын хувийн хэрэг нугалж мэргэжилтнүүдэд олгоход бэлтгэв. Газрын удирдлагын хэлтсийн мэргэжилтнүүдэд 90 ширхэг нэгж талбарын хувийн хэргийн хавтас олгож, кадастрын мэдээллийн санд өөрчлөлт оруулсны төлбөрийн баримт 198 ширхэгийг хүлээж авч бүртгэв.
- ✚ Шаардах хуудсаар 5 төрлийн 48,5 ширхэг бараа материал олгов. 3-р сарын бараа материалын тайлангийн нэгтгэлийг гаргаж ня-бо-д өгөв. Агентлагаас ирсэн 10 ширхэг тусгай хэрэгцээний газар ашиглах гэрчилгээг хүлээж авав.



Үндсэн хөрөнгө, бараа материалын картын мэдээллийг шинэчлэн кодлож хэвлэхэд бэлэн болгов.

Өргөдөл гомдол шийдвэрлэлтийн талаар:

ГХБХБГ-т 2022 оны 3 сарын 24-ний өдрөөс 4 сарын 28-ны өдрийн хооронд Абле программд нийт 144 албан бичиг /хариутай 107/, 62 өргөдөл /хариутай 57/ ирсэнээс 53 албан бичиг, 25 өргөдөл шийдвэрлэн, 54 албан бичиг, 32 өргөдөл хяналтанд бүртгэжээ.

Албан бичиг, өргөдлийн шийдвэрлэлтийг графикаар харуулбал:

График 1. Албан бичиг, өргөдлийн шийдвэрлэлт, хяналтанд авч судлаж буй талаарх мэдээлэл



Мөн Egazar.gov.mn системээр 333 өргөдөл хүсэлт хүлээн авсан бөгөөд тус системийн шийдвэрлэлтийн тайлан гаргадаг цэс нь одоогоор ажиллахгүй байгаа тул шийдвэрлэлтийн дүнг гаргах боломжгүй байна.

БОЛОВСРУУЛСАН:

ЗАХИРГАА, ХУУЛИЙН АСУУДАЛ

ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН

Б.ЗОЛБАЯСАХ

ХЯНАСАН:

ГАЗРЫН УДИРДЛАГЫН

ХЭЛТСИЙН ДАРГА

Г.НЯМДОРЖ